

Трансфер фактор Эдвенсдийн дархлаа дэмжих чадамжийн харьцуулсан судалгаа

Л.Пүрэвдулам¹, Б. Саранцэцэг¹, Д.Арьяа¹
¹Шинэ Анагаах Ухааны Их Сургууль

Судалгааны ажлын үндэслэл:

Дархлал дутмагшлийн хэв шинж манай оронд төдийгүй дэлхий дахинд олширч байгаа билээ. Зүрхний шигдээс, цус харвалт, судасны хатуурал гэх мэт ямарч өвчний хурц үед дархлалын тогтолцоо сулардаг.

Иймээс бид Дэлхийн 50 гаруй оронд өргөнөөр хэрэглэгдэж байгаа дархлааны тогтолцоог өвөрмөцөөр идэвхжүүлэх үйлчилгээтэй Трансфер факторыг сонгон авч уламжлалт анагаах ухаанд бие махбодыг тамиржуулах үйлдэлтэй хэмээн хэрэглэгддэг барагшүн, алтан гагнуур хоёрын найрлагатай “Тамиржуулагч” бэлдмэлтэй харьцуулан түүний үйлдлийг эсийн мембран редокси потенциалын төлөв байдалтай уялдуулан судалсан.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Трансфер факторын дархлал сэргээх үйлдлийг уламжлалт анагаах ухаанд хэрэглэгддэг тамиржуулах үйлдэл бүхий бэлдмэлтэй харьцуулан судлах ерөнхий зорилгын хүрээнд Трансфер факторын дархлаа сэргээх үйлдлийг цагаан хулганад ХЦУЭ-ээр үүсгэсэн дархлаа дутагдлын загвар дээр “Тамиржуулах бэлдмэл”-тэй харьцуулан судлах зорилт тавьлаа.

Судалгааны ажлын арга зүй:

Туршилтын 20-25гр жинтэй цагаан хулганад Трансфер фактор Эдвенсдийн дархлал дарангуйлалгүй үеийн дархлалын тогтолцоонд нөлөөлөх үйлдлийг судлахдаа уг бэлдмэлийг 0,05 гр тунгаар тооцон өдөрт 2 удаа, нийт 3 өдөр зондоор уулгасны дараа Т-хамааралт тест антиген болох хонины цусны улаан эсийг (ХЦУЭ) 10%-0,2 мл-

ээр сүүлний хураагуур судсаар тарьж, дархлалын урвалыг өдөөсний 5 дахь хоногт дархлалын урвалын эрчимд дээрх бэлдмэлүүдийн үзүүлэх нөлөөг дэлүүний жин (г), дэлүүний эсийн тоо/ $\times 10^6$ эс/мл, дэлүүний индекс, ХЦУЭ-ийн эсрэг үүссэн эсрэг биеийн таньц болох гемагглютинины титр (%) (Ерне 1963, И.Е.Ковальев 1976, Пентров Р.В 1980) зэрэг үзүүлэлтээр харьцуулан тодорхойлов.

Дэлүүний эсийн тоог тодорхойлохдоо: Хулганы дэлүүний эсийг шилэн гомогенизаторт Хэнксийн уусмал бүхий орчинд шахан гаргаж, эх биенээс нь салган хөвмөлжүүлж, Горяевын тор ашиглан микроскопт тоолно.

Дэлүүний индексийг тодорхойлохдоо: Хулганы дэлүүний жинг биеийн жинд нь харьцуулах замаар тооцоолов.

Гемагглютинины таньцыг цусны улаан эс наалдуулах урвалын аргаар тодорхойлж хувиар илэрхийлэв.

Судалгааны ажлын үр дүн:

Трансфер фактор Эдвенсдийн дархлалд нөлөөлөх идэвхийг судалсан дүн

ХЦУЭ-н суспензийг тарьсны дараах 5 дахь хоногт эрүүл бүлгийн амьтадын дэлүүний индексийг хяналтын бүлгийн амьтадтай харьцуулахад 1.55 дахин буюу 35.7%-аар ихэссэн (хяналтын бүлэгт 0.014 ± 0.017 , эрүүл бүлэгт 0.009 ± 0.001 , $P < 0.001$), Трансфер фактор Эдвенсд хэрэглэсэн бүлгийн амьтдын үзүүлэлттэй харьцуулахад (хяналтын бүлэгт 0.014 ± 0.017 , Трансфер фактор Эдвенсд хэрэглэсэн бүлэгт 0.006 ± 0.001 , $P < 0.001$) 2.33 дахин багассан байна.

Цагаан хулганад ХЦУЭ-ээр үүсгэгдсэн дархлалын урвалын идэвхжилтийн загвар дээр дэлүүний эсийн тоо өөрчлөгдөх байдал, түүнд трансфер факторын үзүүлэх нөлөөг судлахад туршилтын 5 дахь хоногт эрүүл бүлгийн амьтдын дэлүүний эсийн тоог хяналтын бүлгийн амьтдын үзүүлэлттэй харьцуулахад (хяналтын бүлэгт $224.5 \pm 106.08 \times 10^6$ эс/мл, эрүүл бүлэгт $254.125 \pm 26.71 \times 10^6$ эс/мл, $p > 0.05$) 1.13 дахин буурч, харин Трансфер фактор Эдвенсд хэрэглэсэн бүлгийн амьтадтай харьцуулахад (хяналтын бүлэгт $224.5 \pm 106.08 \times 10^6$ эс/мл, эрүүл бүлэгт $240 \pm 53.58 \times 10^6$ эс/мл, $p < 0.05$) 1.7 дахин ихэссэн байна.

Түүнчлэн туршилтын 5 дахь хоногт ХЦУЭ-ийн эсрэг үүссэн эсрэг биеийн титр хяналтын бүлгийн амьтад 0 минутад 0.125 ± 0.35 , 48 цагийн дараа 1 ± 0.53 байсан ба Трансфер фактор Эдвенсд хэрэглэсэн бүлгийн амьтад 0 минутад 1.9375 ± 1.18 , 48 цагийн дараа 2.6875 ± 1.41 болж ихэссэн ба харин Тамиржуулагч эмийн бэлдмэлээр эмчилсэн бүлэгт 0 минутад 1.625 ± 1.30 , 48 цагийн дараа 1.875 ± 1.55 болж ихэсч байгаа нь идэрлээ.

ДҮГНЭЛТ

Трансфер фактор Эдвенсдийн нөлөөгөөр цагаан хулганад ХЦУЭ-ийг $100 \mu\text{g}/\text{mouse}$ тунгаар судсанд тарьж, иммунизаци явуулах үед идэвхижсэн cytotoxic T lymphocyte буюу Т киллер эсийн тоо хулганы дэлүү,

тунгалгын зангилгааны эсүүдийн нийт популяци дотор 1.43-2.33 дахин ихэсч байгаа нь илэрлээ. Судалгааны энэ үр дүн нь Трансфер фактор Эдвенсд нь хорт хавдар, С, В вирусын халдвар бүхий элэгний эсийн архаг үрэвсэл, элэгний хатуурал зэрэг Т киллер эсийн дутагдал дээр суурилан сэдээгддэг эмгэгүүд болон уг эсийн идэвхийг дээшлүүлэх шаардлага бүхий эмнэлзүйн бүх тохиолдолд хэрэглэхэд нэн тохиромжтой бэлдмэл болохыг харуулж байна.

Ном зүй:

1. Батбаатар.Г, Цогтсайхан.С, Чимэдцэрэн.С, Баттогтох.Ч, Дархлал судлал УБ 2011
2. Хадхүү.В, Өнөржаргал.Х, Дархлалын хувьсгал УБ 2008
3. Хадхүү.В, Өнөржаргал.Х, Гал уураг УБ 2010
4. Lawrence H.S. The cellular transfer of cutaneous hypersensitivity to tuberculin in man//Prog. Sos. Exp. Biol. Med. – 1949, 71, p. 561.
5. 4 Life research the Science of Success USA 2007
6. Методические рекомендации министерства Здравоохранения и Социального развития РФ “Иммунореабилитация инфекционно-воспалительных и соматических заболеваний с использованием Трансфер Фактора” Москва 2004.

**Comparative study of immune moderating effects of
transfer factor advanced**

*L.Purevdulam¹,
B.Sarantsetseg¹, D.Ariya¹
¹New Medical University*

The immunodeficiency is too common in whole the world including this country. The myocardial Infarct, stroke, atherosclerosis and many other disorders develops in fact secondary immune deficit of human being.

We aimed to study the immune stimulating capacity of transfer factor advanced which used more than 50 countries in the world as a strong immune modulator, comparatively with other commonly used convalescents in our traditional medicine like bargashun and altan gagnuur and their membrane peroxidase potential as well.

For this study were used white mouse's with 20-25g of weights. All mouse's were taken orally 0.05g of transfer factor advanced during 3 days 2 times per day and at the end were injected with 0.2 ml - 10% fresh red cell

of sheep once which chosen as T-cell dependent stimulator test antigen. 5 days later were examined spleen index and counted newly generated antibody titer against sheep red cell.

The study result show that under the influence of transfer factor advanced after immunization (by 100 mg/mouse sheep red cell), the amount of cytotoxic T lymphocyte (T killer) cells among whole T lymphocyte population in the spleen and nearby lymph nodes of white mouse's were perceptibly increased (1.43-2.33 P<0.001). It gives to conclude transfer factor advanced should have high treatment effects for several cancers, chronic liver disorders with B and C viruses hepatitis, cirrhoses etc., which develops due to deficit of T killer cell.

*Танилцаж санал ирүүлсэн АУ-ны доктор,
дэд профессор Н.Батчимэг*